



“УЛААНБААТАРЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019-12-13 № 05/10651  
танай \_\_\_\_\_-ны № 1/2809

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Сүхбаатар хэрэглэгчдэд үйлчлэх төвийн даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Колягийн Эрдэнэбаярын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч К.Эрдэнэбаяр нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Хашбаатар* Х.ХАШБААТАР

